

“ЭРДЭНИЙН БОСГО” ХХК

“ХУЛМАН НУУР НҮҮРСНИЙ
ОРДЫГ АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ОРШИЛ	1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. “Эрдэнийн босго” ХХК-ийн үйл ажиллагаа	2
1.2. Төслийн байршил	3
1.3. Хүчин чадал, техник, технологи	4
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	5
2.1. Газрын гадарга, байр зүй	5
2.2. Цаг уур, уур амьсгал	5
2.3. Агаарын чанар, дуу чимээ	5
2.4. Геоморфологи	5
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал	5
2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал	6
2.7. Амьтны аймаг	6
2.8. Гадаргын ус	6
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	7
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7
3.2. Нөхөн сэргээлт	8
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	8
3.4. Осол, эрсдэл	8
3.5. Хог хаягдлын төлөвлөгөө	9
3.6. “Тэр бум” мод	9
3.7. Нүүлгэн шилжүүлэлт	9
3.8. Түүх, соёлын өвийг хамгаалах	9
3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10
3.10. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	10
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	15
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
4.5. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн	19
4.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	19
4.7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
4.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	21
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн байршил	3
Зураг 2.	Төслийн дэд бүтэц.....	4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол	3
Хүснэгт 2.	Уурхайн ажиллах горим	4
Хүснэгт 3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 4.	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 5.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 16	
Хүснэгт 6.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 8.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж ургуулах тухай.....	19
Хүснэгт 9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
Хүснэгт 10.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	21
Хүснэгт 11.	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	22
Хүснэгт 12.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн.....	23

ОРШИЛ

“Эрдэнийн босго” ХХК-ийн “Хулман нуур нүүрсний ордыг ашиглах”-ийн /цаашид “Төсөл” гэх/ зориулалттай төслийн газар нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт 1228.66 га талбайг хамран оршиж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Эрдэнийн босго” ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Эрдэнийн босго” ХХК
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 37Б, Монреимпекс байр, 602 тоот
Төслийн байршил, хаяг:	Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум, Хулман нуур
Нийт талбайн хэмжээ:	1228.66 га талбай
Газар ашиглах зориулалт:	Уул уурхай
Газар ашиглах, эзэмших шийдвэр:	MV-017480
Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:	9011143123
Регистрийн дугаар:	5211859
Дэд бүтэц:	Дулаан хангамж: Усан халаалтын зуухаар халаалтыг шийдвэрлэдэг. Усан хангамж: Гүний худгаас хэрэглээний усаа хангана. Худаг-1 ундарга 1л/сек Худаг-2 ундарга 2л/сек Хэрэглээнээс гарах бохир ус: Бохир ус хадгалах 120 тн, саванд хадгалдаг. Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Цахилгаан хангамжийн эх үүсвэрт холбогдсон.

1.1. “Эрдэнийн босго” ХХК-ийн үйл ажиллагаа


Төслийн зорилго

“Эрдэнийн босго” ХХК нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Хулман нуур”-ын хүрэн нүүрсний ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллах, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн нөхөн сэргээлтийг зохих стандартын дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөхөд энэхүү төслийн зорилго оршино.

Төслийн байршил

Төслийн талбай нь Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн 9011143123 тоот гэрчилгээтэй Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Хулман нуур” нэртэй газар орших 1228.66 га бүхий уурхайн талбайтай.

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



Зураг 1. Төслийн байршил

Хүснэгт 1. Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол

№	X	Y
1	115°45'31.00"E	45°43'52.00"N
2	115°45'31.00"E	45°45'41.00"N
3	115°42'42.00"E	45°45'41.00"N
4	115°42'42.00"E	45°43'52.00"N

1.2. Төслийн байршил

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум нь Улаанбаатар хотоос 760 км, Эрдэнэцагаан сумын төвөөс зүүн урагш 46 км, Бичигтийн боомтоос 40 км зайд байрладаг. Эрдэнэцагаан сумын нутагт Нүхт, Баянцогтын нүүрсний уурхай ажиллаж Бичигтийн боомтоор бүтээгдэхүүнээ БНХАУ-руу экспортолдог тул тус суманд гадаад харилцаа нэлээд хөгжсөн.



Зураг 2. Төслийн дэд бүтэц

1.3. Хүчин чадал, техник, технологи

“Эрдэнийн босго” ХХК-ийн Хулман нуурын нүүрсний уурхайн жилийн хүчин чадлыг 2.5 сая.тн байхаар төсөлд тусгасан байна. Дээрх хүчин чадлаар ил уурхайн хүрээн дэх нөөцийг 34 жил ашиглахаар ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулсан.

Уулын ажлын горим

Уурхай нь жилд тасралтгүй горимоор ажиллах ба ажлын хоногийг Монгол улсын нийтээр тэмдэглэх баяр ёслолын өдрийг хөдөлмөрийн хуулийн дагуу хасаж тооцсоноор гаргав. Мөн цаг агаарын байдлаас хамааран саатах өдрүүдийг хасаж тооцсон.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Жилийн календарь хоног	Хоног	365
2	Жилд ажиллахгүй хоног	Хоног	8
3	Баяр ёслол	Хоног	3
4	Цаг агаарын саатал	Хоног	5
5	Уурхайн жилийн ажиллах хоног	Хоног	357
6	Хоногт ажиллах	Ээлж	2
7	Жилд ажиллах ээлжийн тоо	Ээлж	714
8	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадарга, байр зүй

Монгол Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг муж, Дарьгангын тэгш өндөрлөг талархаг тойрогт хамаарагддаг. Монгол орны геоморфологийн мужлалаар Дорноговийн цав толгодорхог мужид ордог. Хотгор гүдгэрийн хэв шинжээрээ цав толгодын хэв шинжтэй, цэрдийн галавын газарзүйн байрлалаар нүүрс хуримтлалын нутагт хамаарагддаг ба юра галавын үеийн галт уултай нутагт багтдаг.

2.2. Цаг уур, уур амьсгал

Төслийн талбай нь уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд Дорнод хэсгийн хүйтэн өвөлтэй хуурай эх газрын мужид хамаардаг. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 3.7°C бол зуны улиралд хамгийн их температур нь 60°, өвлийн улиралд -42°C хүрч байсан. Жилийн дундаж температур нь 1.7°C, хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.7°C бол хамгийн дулаан сар болох 6-р сарын дундаж температур 21.7°C байдаг байна.

2.3. Агаарын чанар, дуу чимээ

Уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор машин механизмын хөдөлгөөнөөс бага зэрэг тоосжилт үүснэ. Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт дэгдэх зэргээр агаарын чанар, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дуу чимээний дундаж утгын түвшин Монгол улсын MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ба дуу чимээний хамгийн их утга нь Монгол улсын MNS4585:201 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй юм.

2.4. Геоморфологи

1975 онд М.Беспалов төслийн талбайн хойд хэсэгт Эрдэнэцагаан сумын нутагт Баянхайлааст, Нүхтийн ховор металлын хэд хэдэн илрэл дээр ерөнхий эрлийн ажил явуулж Ордовикийн настай занар, элсэн чулуулгийн зузаалаг, дунд-дээд зузаалаг, дунд-дээд Юрагийн бялхмал чулуулаг, доод Цэрдийн Цагаанцав формацын тунамал бялхмал зузаалаг, Неогений алаг өнгийн хурдас, доод Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас хэмээн тус тус ангилсан байна.

2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Монгол орны хөрсний ангиллаар хээрийн хөрсний бүлэгт багтах нимгэн хар хүрэн, ердийн хар хүрэн гэсэн 3 төрлийн хөрс зонхилон тархсан байна. Нимгэн хар хүрэн хөрс нь талбайн хойд хэсгийн уулархаг газрын энгэр орой олон гадаргын налуужилт ихтэй хажуу энгэр хэсгээр, ердийн хар хүрэн хөрс нь толгодын ар хажуугийн сүүдэрхэг газруудаар болон судаг, хөндий дагуу гадаргын чулуужилт багатай тэгшивтэр газруудад, ердийн хүрэн хөрс нь талбайн төв болон урд хэсгийн энгэр бэл газарт тус тус тархсан байна.

2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал

Талбайн хэмжээнд тал хээрийн ургамал зонхилох ба ургамлын бүтэц сайн, хээр талын ялзмаг сайтай хүрэн хөрстэй. Талархаг нугаараа хиаг, таана, монгол өвс, баглуур, шивээ, агь, шарилж, халгай, дагуур, сонгино, хайлаар буюу зэрлэг саримс, мангир, хөмүүл зэрэг ургамал ургана.

Төслийн талбай орчимд Хөндлөн хайлаасны ам, Тэрэгтийн ам зэрэг газруудад цөөн тооны хайлаас ургадаг бөгөөд Ачаа чулууны хад, Хадат ухаа, Бор-Өндөр толгой орчмоор бэлчээрийн нарийн өвс /хадлангийн өөц/ ихээр ургана. Лхачинвандад уул түүний ойр орчимд эмийн ургамал ургадаг ба байгалийн нөөц газар юм.

2.7. Амьтны аймаг

Эрдэнэцагаан сум нь Монгол орны зэрлэг хөхтний газар зүйн мужлалаар хээрийн ба Баруун тойргуудад хамаарна. Энэ бүс нутаг нь Зүүн Азийн зарим зүйлийн (нохой, элбэнх, манж номин, дорнын сармаахай) зэргийн тархцын баруун хязгаар, мөн Төв Азийн уул, Говь, цөлийн олон зүйлийн (хар сүүлт, монгол тарвага, өөхлөг тагжиг даахай, шар чичүүл, дэлдэн зараа) тархцын зүүн, төв азийн уугуул зүйл цагаан зээрийн популяцийн байршил, тоо толгой, үржлийн үндсэн голомт нутаг юм.

Энэхүү тойрог 6 баг, 16 овог, 43 төрлийн 70 зүйл буюу Монгол орны зурлаг хөхтний зүйлийн 50.7%-ийг эзэлдэг бол Эрдэнэцагаан сумын нутагт 6 багийн 9 овог 23 төрөл 27 зүйл хөхтөн амьтан нутаглаж байна.

2.8. Гадаргын ус

Сүхбаатар аймгийн нутгийн хойд болон зүүн хэсэг нь Номхон далайн ай савд бусад хэсэг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарахын зэрэгцээ гадаргын урсац сарних бүсэд оршдог. Иймд тус ай савын гадаргын усан сүлжээ нь хэмжээгээрээ нэлээд бага, тэдгээрийн гадаргын урсцын байгалийн горим нэлээд тогтворгүй, ихэвчлэн хатаж ширгэдэг. Аймгийн нутаг дэвсгэрт нийт 23 гол горхи, 11 рашаан, 382 булаг шанд, 1064 нуур, тойром бүртгэгдсэн байна.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Агаар

Агаарын чанарын гадаад орчны түгээмэл тархацтай бохирдуулах бодисыг хянахдаа “Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандартаар, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 стандарт”-аар, Ажлын байрны орчны бичил цаг уурын эрүүл ахуйн шаардлага, агаар дахь хорт бодисыг хянахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023 стандартаар тодорхойлж төсөл хэрэгжүүлэгч эдгээрээс давах бохирдуулагч гаргахгүй байхад үндэслэгдэнэ.

- Эко барьцалдуулагч бодисыг ашиглах туршилтыг хийх
- Замын засвар үйлчилгээг тогтмол хийх
- Уурхайн дотоод болон гадаад тээврийн замд тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах
- Нүүрс өөрөө шаталтаас сэргийлэх, галыг даруй дарах, бэлтгэл хангах
- Техник тоног төхөөрөмжийг тогтмол оношилгоонд оруулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх
- Агаарын орчны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэж, дүгнэлт, зөвлөмж авч, гарсан хариуд үндэслэн арга хэмжээ авах

Гүний ус

Гүний усанд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Ус ашиглуулах дүгнэлтийг Усны газраар гаргуулж, заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй
- Гүний худагт эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, хашаажуулах
- Гүний худагт тоолуур суурилуулах
- Усны чанарын өөрчлөлт, бохирдлыг хянах
- Шүүрлийн усыг зам усалгаа болон мод усалгаанд ашиглах

Хөрсөн бүрхэвч

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Түлш, шатах тослох материалаар хөрс, бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээг авч ажиллана.
- Ашиглалтын талбайд олон салаа зам үүсэхээс сэргийлж тэмдэг тавих, хаалт хийх
- Засварын цех болон ШТС-ийн талбайг хайрга эсвэл хатуу хучилттай болгох
- Хогийн цэгийг тохижуулах
- Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх

Ургамал, амьтан

Төслийн үйл ажиллагаанаас ургаман нөмрөг талхлагдах, дарах зэргээр зүйлийн бүрдлийн тоо цөөрөх улмаар устгах мөн тоосжилт болон утааны бохирдлоос үүдэн уурхайн ойролцоох орчны ургамал тоосонд дарагдаж, доройтох зэрэг сөрөг нөлөөллүүд гарах тул талбайг хамгаалах нь чухал юм. Тиймээс төслийн талбайд дараах зүйлүүдийг хийх шаардлагатай. Үүнд:

- Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, тогтмол маршрутын дагуу тээвэрлэлт хийх
- Тоосны хуримтлал үүсэж, ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол услах
- Төслийн хэрэгжилтээс үүдэлтэй хог хаягдлыг ангилан ялгах, цэгийг бий болгох
- Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх аймгийн мониторинг судалгааг том хөхтөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх

3.2. Нөхөн сэргээлт

- Шимт хөрсний овоолго байгуулна.
- Шимт хөрсийг нөхөн сэргээлтэд зориулан хураана.

3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

“Эрдэнийн босго” ХХК-ний уурхайн орчинд биологийн олон янз байдлын судалгаа, шинжилгээ хийх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлыг холбогдох аргачлалын дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг Лхачинвандад уулын БНГазарт тооцож оруулав.

3.4. Осол, эрсдэл

- Уурхайн ажлын явцад үүссэн аюул ослоос сэргийлэхийн тулд аюулгүйн тууз татах
- Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах саванд хадгалах
- Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах эсвэл бетондуулах
- Аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх
- Аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгалд хяналт тавих
- Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах
- Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх. Тэсэрч дэлбэрч болох материалын хадгалалт болон асгаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах

3.5. Хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын тухай 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн /шинэчилсэн найруулга/ хууль нь 8 бүлэг 43 зүйлээс тогтох ба тус хуулийн 1-р зүйлд заасан хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, ажилчдын хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Ахуйн хог хаягдал

- Хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах
- Хог хаягдлын битүүмжлэх бүхий цэгүүдийг байгуулах
- Эрдэнэцагаан сумтай гэрээ байгуулан хатуу хог хаягдлыг ачиж зайлуулах
- Төслийн талбайд үүссэн хог хаягдлын бүртгэл хөтлөх

Аюултай хог хаягдал

- Аюултай хог хаягдлуудыг паспортжуулах
- Аюултай хог хаягдлын бүртгэлийг бий болгох
- Аюултай хог хаягдлыг ангилан ялгах сургалт сурталчилгааг ажилчдад өгөх
- Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн зөөж тээвэрлүүлэх
- Хуримтлагдсан аюултай хог хаягдлын хэмжээний талаар бүртгэл хөтлөх

Уурхайд ашиглагдаж буй хүнд даацын машин техникийн ашиглалтын явцад дугуй, аккумулятор, ашигласан тос масло уурхайн хатуу хаягдал үүснэ. Дээрх хаягдлууд нь аюултай хог хаягдалд орох тул зохих журмын дагуу зайлуулж, устгах нь зүйтэй юм. Иймд тус компани аюултай хог хаягдлыг дахин боловсруулдаг ашигласан аккумулятор, “Алтан Оршихуй Ресайклинг” ХХК-д хаягдал дугуй, бүх төрлийн резин хог хаягдал, ашигласан тосоо нийлүүлэх замаар уурхайн хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулна.

3.6. “Тэр бум” мод

Монгол улсын ерөнхийлөгч НҮБ-ийн ерөнхий Ассамблейн 76-р чуулган дээр Байгаль орчны доройтол, цөлжилт, хар шороон шуургатай тэмцэх зорилгоор Монгол улс 2030 он гэхэд нэг Тэр бум мод тарьж ургуулахаа зарласан бөгөөд энэ хөтөлбөрийн хүрээнд “Эрдэнийн босго” ХХК нь заагдсан талбайд 1200ш мод сөөгийг тариалахаар төлөвлөөд байна.

3.7. Нүүлгэн шилжүүлэлт

“Эрдэнийн босго” ХХК-ийн үйл ажиллагаа нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багт уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд төслийн талбайд нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.

3.8. Түүх, соёлын өвийг хамгаалах

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд ямар нэг түүх, соёлын өв, дурсгал зүйлс байхгүй тул хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-д сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

3.10. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

- Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх
- Гал тогооны хэсэгт ажиллах хүн бүрийг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
- Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах
- Ажлын байрны байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн багууллагын зөвлөгөө авах
- Байгаль орчны аудит хийлгэх
- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгүүлэх

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2012 оны 05 дугаар сарын 17 өдрийн /Шинэчилсэн найруулга/ “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа “Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилт	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор үйл ажиллагаанд эко барьцалдуулагч бодисыг ашиглах туршилтыг хийлгэх. /Жич: Туршилтын явцад тухайн бүтээгдэхүүний сонголтыг тодорхой болгоно/	Ил уурхай	M ³ /сар	4,250.0	-	4,250.0	2024 он	Агаарын тухай /Шинэчилсэн найруулга/, /2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр/ 19.2, 20.1
2	үүссэнээр орчны агаар бохирдох, хүний эрүүл мэнд болоод хүлээн буй	Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах		M ³	ҮА-ны зардлаар			2024 он	
3	орчны /амьтан, ургамал/-д сөрөг нөлөө үзүүлнэ	Уурхайн дотоод тээврийн болон гадаад тээврийн болон тээврийн замд хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээ байршуулах		Ширхэг	50.0	4	200.0		
4	Нүүрсний өөрөө шаталт уугилт үүсэж орчныг бохирдуулах	Нүүрсний өөрөө шаталтаас сэргийлэх, өгөршлийн бүсэд халалт гарсан үед галыг даруй дарах, бэлтгэл хангах	Ил уурхай	ҮА-ны зардлаар			2024 он	“Ашигт малтмалын тухай” /Шинэчилсэн найруулга/ 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр	
5	Техник, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах бохирдуулагч	Техник тоног төхөөрөмжийг тогтмол оношилгоонд оруулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх	Уурхайд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, техник	ҮА-ны зардлаар			2024 он	“Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам батлах тухай ” /2012	

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	орчны агаарыг бохирдуулах								оны 12 дугаар сарын 31/ Дугаар А/199
6	Агаар орчин бохирдох	Агаар орны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, дүгнэлт гаргуулах зөвлөмж авах, гарсан хариуд үндэслэн арга хэмжээ авах	ОХШХ-т тусгагдсан				2024 он	Агаарын тухай хууль /2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр/	
Усан орчин									
7	Усыг заасан хэмжээнээс хэтрүүлж ашиглах	Ус ашиглуулах дүгнэлтийг Усны газраар гаргуулж, заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн талбай	645.0				2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
8	Ус ашиглах эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах	Гүний худагт эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, хашаажуулан дэглэмийг мөрдөж ажиллах	Гүний худаг	Ширхэг	300.0	2ш	600.0	2024 он	Усны тухай /Шинэчилсэн найруулга/ 12.1.4
9	Усны хэрэглээ, ашиглалт ихсэх, усны түвшин буурах	Гүний худагт тоолуур суурилуулах		Ширхэг	250.0	2ш	500.0	2024 он	
10	Усны чанарт өөрчлөлт орох	Усны чанарын өөрчлөлт, бохирдолтыг хянах	Уурхайн гүний 2ш худаг болон шүүрлийн ус	М³	125.0	1 удаа	250.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доор усны тухай
11	Шүүрлийн усны үр ашиггүй хэрэглээ гарах	Усны нөөцийг алдагдалгүйгээр ашиглах зорилгоор усыг зам усалгаа болон мод усалгаанд ашиглах	Уурхайн шүүрлийн ус	М³	ҮА-ны зардлаар			2024 он	
Хөрсөн бүрхэвч									
12	Хөрсөнд шатах тослох материал алдагдах, өнгөн хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллана	Төслийн талбай	Удаа	ҮА-ны зардлаар			2024 он	Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал Дугаар 256

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

13	Төлөвлөгдөөгүй замаар тээвэр хийж олон салаа зам гаргаж өнгөн хөрс доройтуулах	Ашиглалтын талбайд олон салаа зам үүсэхээс сэргийлж тэмдэг тавих, хаалт хийх	Төслийн талбай	Ширхэг	ҮА-ны зардлаар			2024 он	MNS6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх үр тарих, арчлах
14	Засварын цех болон ШТС орчимд түлш, шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	Засварын цех болон ШТС-ийн талбайг хайрга эсвэл хатуу хучилттай болгох	Төслийн талбай болон түүний орчим	M ²	5,000.0			2024 он	Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр
15	Ахуйн болон бусад энгийн хог хаягдлаар хөрс бохирдох	Хогийн цэгийг тохижуулах	Уурхайн түр хогийн цэг	Ширхэг	500.0	1	500.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, “Хог хаягдлын тухай” хууль Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019
16	Хөрсний бохирдол	Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх	Уурхай орчмын бүс	ОХШХ-т тусгагдсан				2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/
Ургамал, амьтан									
17	Ургамлын доройтол	Ургамалан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Мян.төг	500.0	1 удаа	500.0	2024 он	Ургамал хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ 2007 он 11 дүгээр сарын 15-ны өдөр
18		Олон салаа зам гаргахгүй байх, тогтмол маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Уурхай орчмын талбай	Хөрс хамгаалах арга хэмжээнд оруулсан				2024 он	БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-318 дугаар тушаал

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

19		Тоосны хуримтлал үүсэж ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол услах	Уурхайн олборлолт явуулж байгаа талбай	ҮА-ны зардлаар			2024 он	хавсралт “УУ-н үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Эвдэрсэн газрыг ургамалжуулах”	
20		Төслийн хэрэгжилтээс үүдэлтэй хог хаягдлыг ангилан ялгах, цэгийг бий болгох	Төслийн хогийн цэг болон түр хогийн цэгүүд	Ширхэг	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан		2024 он		
21	Ургамлын доройтол	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Мян.төг	500.0	1	500.0	2024 он	Ургамал хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ 2007 оны 11 дүгээр сарын 15
22	Амьтдын тархалт, үргэн дайжих	Амьтны аймгийн мониторинг судалгааг том хөхтөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх		Мян.төг	500.0	1	500.0	2024 он	Амьтны тухай /Шинэчилсэн найруулга/ 2012 оны 05 дугаар сарын 17 өдөр
НИЙТ ЗАРДАЛ					12,800.0 МЯН.ТӨГ				

4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолго байгуулна. Шимт хөрснийг нөхөн сэргээлтэд зориулан хураана.	М ²	-	10,000.0		2024 он	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө А/618 журам /2019 оны 10 дугаар сарын 29/
НИЙТ ЗАРДАЛ					10,000.0 МЯН.ТӨГ			

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ойролцоо уст цэг байгуулах	Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сумын нутаг Лхачинвандад уулын БНГазарт	Ширхэг	1		15,000.0	2024 он	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр /Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолын хавсралт/
НИЙТ ЗАРДАЛ						15,000.0 МЯН.ТӨГ		

4.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй осол, нөлөөлөл	аюул, сөрөг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн ажлын явц дахь болзошгүй		Аюулгүй тууз татах	Уурхайн орчинд	100м	10.0	1,000.0	2024 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр/
2	Шатах тослох материал шатах эрсдэлээс сэргийлэх		Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах саванд хадгалах		ҮА-ны зардлаар			2024 он	Газрын тосны бүтээгдэхүүний тухай /2005 оны 7 дугаар сарын 1-ны өдөр/
3	Шатах тослох материалын асгаралт		Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах, бетондуулах		Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан			2024 он	
4	Аюултай хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл		Аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх	Уурхайн болон кемп орчин	ҮА-ны зардлаар			2024 он	Химийн хорт болон аюултай бодисын тухай /2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр/
5			Аюултай хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих		1	50.0	50.0	2024 он	
6					ҮА-ны зардлаар			2024 он	

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх, уурхайн үеийн усанд автах	Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах				“Гамшгаас хамгаалах тухай” /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 02 сарын 02 өдөр
7	Хээрийн түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх. Тэсэрч дэлбэрч болох материалын хадгалалт болон асгаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах	Уурхай орчмын талбай болон уурхайн бүс	ҮА-ны зардлаар	2024 он	“Ой хээрийн түймэр унтраахад оролцуулах тухай” 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Дугаар-09
НИЙТ ЗАРДАЛ					1,050.0 МЯН.ТӨГ	

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг ангилах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мөн.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтжуулах эрх зүйн баримт бичиг	
1	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлуудыг паспортжуулах	Төслийн талбай	ҮА-ны зардлаар				2024 он	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах, журам /2018 оны 116 тогтоолын 1 дүгээр хавсралт/	
2		Аюултай хог хаягдлын бүртгэлийг бий болгох		Хүн/цаг	10.0	1	10.0			
3		Аюултай хог хаягдлыг ангилан ялгах сургалт сурталчилгааг ажилчдад өгөх	Нийт ажиллагсад	ҮА-ны зардлаар						
4		Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн зөөж тээвэрлүүлэх	Төслийн талбай	Удаа	100.0	8	800.0			
5		Хуримтлагдсан аюултай хог хаягдлын хэмжээний талаар бүртгэл хөтлөх		ҮА-ны зардлаар						
6	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай	ҮА-ны зардлаар						Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 5 дугаар сарын 12 өдөр
7		Хог хаягдлын битүүмжлэх бүхий цэгүүдийг байгуулах		Ширхэг	200.0	3	600.0			
8		Эрдэнэцагаан сумтай гэрээ байгуулан хатуу хог хаягдлыг ачиж зайлуулах		ҮА-ны зардлаар						
9		Төслийн талбайд үүссэн хог хаягдлын бүртгэл хөтлөх		ҮА-ны зардлаар						
НИЙТ ЗАРДАЛ				1,410.0 МЯН.ТӨГ						

4.5. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн

Хүснэгт 8. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж ургуулах тухай

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Авах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн	Мод тарих	-	Ширхэг	1200	2.0	2,400.0	2024 он	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
НИЙТ ЗАРДАЛ						2,400.0 МЯН.ТӨГ		

4.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

Төслийн талбайд нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.

4.7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлага мөрдөн ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зааж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр								
1	PM _{2.5} тоосонцор	Уурхайн кемпийн дэргэд хөрсний дээжийн Х-1 зүсэлтийн цэг-45°45'32.07"N	1 удаа		100.0	100.0	Байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж, дүгнэлт, зөвлөгөө авах	Агаарын чанар. Техникийн ерөний шаардлага MNS 4585:2016
2	PM ₁₀ тоосонцор							
3	Азотын давхар исэл (NO ₂)							
4	Хүхэрлэг хий (SO ₂)							
5	Дуу шуугианы хэмжилт							
НИЙТ ЗАРДАЛ					200.0 МЯН. ТӨГ			
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр								
1	Ерөнхий үзүүлэлт	Уурхайн зүүн хойд хэсэгт /А-2, 45°45'7.11"N 115°43'36.64"E/ Уурхайн кемпийн хэсэгт /А-1, 45°45'32.23"N 115°45'7.31"E/	1 удаа	1	50.0	50.0	Нийт 3 дээжийг хөрсний 2 үе давхаргаас авч шинжүүлнэ.	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
2	Хүнд үзүүлэлт		Улиралд 1 удаа	2	100.0	200.0		
3	Нянгийн үзүүлэлт		1 удаа	1	50.0	50.0		
НИЙТ ЗАРДАЛ					300.0 МЯН.ТӨГ			
Газрын доорх усны хяналт шинжилгээний хөтөлбөр								
1	Ерөнхий үзүүлэлт	Уурхайн кемпийн гүний худаг-45°45'32.77"N 115°45'3.20"E Уурхайн шүүрлийн уснаас	Улиралд 1 удаа	2	100.0	200.0	Унд ахуйн ус, бохир ус	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018
2	Хүнд элемент			1	150.0	300.0		
3	Бохир усны шинжилгээ		1 удаа	1	100.0	100.0		
НИЙТ ЗАРДАЛ					600.0 МЯН. ТӨГ			
НИЙЛБЭР ЗАРДАЛ					1,100.0 МЯН. ТӨГ			

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь						Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт, арга аргачлал
			VI	VII	VIII	IX	X	XI		
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	80.0	*	*	*	*	*	*	ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
2	Гал тогооны хэсэгт ажиллах хүн бүрийг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	40.0			*			*	ХАБЭА	Эрүүл ахуйн тухай /2016 оны 2 дугаар сарын 4 өдөр/
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах	200.0	*						ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
4	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	ҮА-ны зардлаар		*					Байгаль орчны ажилтан	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам Дугаар 75 /2023 оны 11 дүгээр сарын 10 өдөр/
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах	200.0	*						Байгаль орчны ажилтан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө Дугаар А/618 /2019 оны 10 дугаар сарын 29 өдөр/
6	Байгаль орчны аудит хийлгэх	Харилцсан тохиролцсноор		*					БОА хийх мэргэжлийн байгууллага	Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчны үнэлгээ, судалгаа шинжилгээ, аудит /Хоёр дугаар бүлэг/, /2012 оны 5 дугаар сарын 17/ 10 дугаар зүйл
7	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгүүлэх	Харилцсан тохиролцсноор			*				Байгаль орчны ажилтан	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам Дугаар 28 /2003 оны 02 дугаар сарын 07-ны өдөр/
НИЙТ ЗАРДАЛ			520.0 МЯН.ТӨГ							

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

Хүснэгт 11. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа	Тайлан мэдээ хүлээн авах тал	Тайлагнах хэлбэр	Тайлагнах огноо	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	БОАЖЯ, Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан	Бичгээр	10-р сарын 30-наас өмнө	500.0	“Эрдэнийн босго” ХХК	-	Аймгийн БО-ны газраар дүгнэлт гаргасан, тайлан дүгнэлтийн хамт БОАЖЯ-д хүргэгдсэн байх.
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн сар бүрийн хэмжилтийн мэдээлэл	Компанийн удирдлагууд	Э-мэйл	Сар бүрийн эхний 5 хоног	250.0		-	Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна.
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сар бүрийн биелэлт, БО-ны багийн үйл ажиллагааны тайлан	Компанийн удирдлагууд	Э-мэйл	Сар бүрийн эхний 5 хоног	250.0		-	Холбогдох тал сар бүр тайлан хүргэгдсэн байна.
НИЙТ ЗАРДАЛ					1,000.0 МЯН.ТӨГ			

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Хулман нуур нүүрсний ордыг ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төг	2024 он	12,800.0
2.	Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө	төг		10,000.0
	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг		15,000.0
3.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг		1,050.0
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төг		1,410.0
5.	Тэр бум мод	төг		2,400.0
6.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	төг		-
7.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг		-
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төг		1,100.0
9.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	төг		520.0
10.	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	төг	1,000.0	
НИЙТ ДҮН				45,280.0 МЯН.ТӨГ